



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-04-09 № 03/55

**Бүртгэлд тусгуулах тухай**

Төрийн өмчийн хорооны 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад тус байгууллагад ашиглагдаж буй Сонота 7 маркын УБҮ 03-35 улсын дугаар бүхий автомашин үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгагдаагүй, Баянгол дүүргийн нутаг дэвсгэр "Гаалийн-2" орон сууцны хонгилд байрлах 10 машины гражид машин тавиулсны орлого болон түүнтэй холбогдон гарч буй зардал нягтлан бодох бүртгэлд тусгагдаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дээрх зөрчлийг арилгаж хэрэгжилтийг 2013 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ТӨХ-ны дарга Д.Цогтбаатар, ерөнхий нягтлан бодогч О.Энхээ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ХҮРГҮҮЛСЭН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР



Ц.ГЭРЭЛ